

СТАТИСТИКИЙН ТАНИЛЦУУЛГА



**Дүүргийн эдийн
засаг, нийгмийн
байдал**

**2016 он
11-р сар**


АГУУЛГА

Хуудасны
тоо

1. ДҮҮРГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	3
2. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	4
3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ	7
4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	8
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	9
6. НИЙГМИЙН ДААТГАЛ	11
7. НИЙГМИЙН ХАЛАМЖ	11
8. УЛААН ЗАГАЛМАЙ	12
9. АЖ АХУЙН НЭГЖ	12
10. АЖ ҮЙЛДВЭР	13
11. ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	14
12. ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ	15
13. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	15
14. ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ	16
15. ЗАХИРГААНЫ МЭДЭЭ	16
16. ГЭМТ ХЭРЭГ	17
17. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ЗӨРЧИЛ	18
18. ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ	18
19. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ	19
20. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ ГАМШИГ	20
21. ЦЭРГИЙН ШТАБ	21
22. АХМАДЫН ХОРОО	21

Хүснэгт 1. Дүүргийн үндсэн үзүүлэлт. 2016 оны 11 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он	2016 он
Суурин хүн ам /жилийн эцэст/	Хүн	159514	154819
Төрөлт	Тоо	4214	3854
Шинээр төрсөн хүүхэд	Тоо	4256	3888
Нас баралт	Тоо	757	640
Халдварт өвчин	Тоо	4148	4027
Ажилгүйчүүд	Хүн	3117	3369
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	2084	2200
Дүүргийн төсвийн орлого	Сая төгрөг	50903.3	58977.8
Дүүргийн төсвийн зарлага	Сая төгрөг	45555.1	58519.0
Валютын ханш	1US\$=₮	1991	2488.49




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2016 оны 11-р сарын хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 хувиар, 2015 оны жилийн эцэстэй харьцуулахад 0.4 хувиар, тус тус буурч, өмнөх 10-р сартай харьцуулахад 0.7 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Хэрэглээний үнийн индекс

Бараа үйлчилгээний бүлэг	Жин	<u>2016.10</u> <u>2015.10</u>	<u>2016.10</u> <u>2016.10</u>
Ерөнхий индекс	99.4	98.6	100.7
Хүнсний бараа, ундаа, ус	98.3	98.5	99.4
Согтууруулах ундаа, тамхи	104.3	104.3	101.0
Хувцас, бөс бараа	98.9	98.7	100.6
Орон сууц, ус, түлш, цахилгаан	95.4	97.2	104.0
Гэр ахуйн тавилга, бараа	100.7	100.6	101.0
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	108.8	107.7	99.8
Тээвэр	98.3	98.3	100.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.6	100.6	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	98.5	98.2	100.4
Боловсролын үйлчилгээ	102.6	102.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	102.5	101.2	101.2
Бусад бараа, үйлчилгээ	101.3	100.9	100.3

Зураг 1. Хэрэглээний үнийн өсөлт сараар



Хэрэглээний үнийн индекс 2016 оны 11-р сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 0.4 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 1.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 6.6 хувь, тээврийн бүлгийн үнэ 1.7 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 1.8 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.


Хүснэгт 3. Бараа бүтээгдэхүүний дундаж үнэ, төгрөг / 11 сар/

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016
Алтан тариа 1-р зэрэг	кг	750	750	1033	1100	1089
Атар талх	ш	650	780	1033	1160	1160
Цагаан будаа	кг	1650	1900	2200	2400	2575
Шар будаа	кг	1550	1400	1667	1567	1730
Хонины мах	кг	6000	7000	6267	4000	4800
Үхрийн мах	кг	7800	8400	8000	6000	6350
Адууны мах	Кг	5800	6000	5900	4567	5300
Тахианы гуя	кг	4000	5500	6600	6667	6600
Сүү задгай	л	1100	1000	1250	1300	1400
Хорхой ааруул	кг	8000	7000	9667	9000	9000
Өндөг	ш	250	280	283	293	300
Ургамлын тос	л	2800	2900	2967	3300	3355
Алим, кг	кг	3500	3000	4000	3667	4170
Банан, шар	кг	3500	4000	5667	5000	5000
Төмс	кг	800	600	833	1100	725
Лууван	кг	1000	800	1000	1200	850
Сонгино	кг	1000	800	1000	1500	1255
Элсэн чихэр	кг	1500	1500	1667	1567	2315
Цэвэр усны үнэ тоолуургүй 1хүний	хүн	3201.6	3201.6	4705.8	4706	4705.8
Эдийн саван ОК	ш	450	450	533	600	650
Угаалгын нунтаг "ОМО"	ш	580	650	800	833	860
Аяга, таваг угаагч шингэн, "Fairy"	ш	2750	3000	3600	4067	4100


Зураг 2. Алтан тариа дээд гурил, атар талхны үнэ, 2012-2016 он




Зураг 3. Нэг кг хонь, үхрийн махны дундаж үнэ, 2011-2016 он



Зураг 4. Нэг кг лууван, төмсний дундаж үнэ, 2011-2016 он



Зураг 5. Нэг кг сонгино, байцааны дундаж үнэ, 2011-2016 он



Зураг 6. Шатахууны үнэ, 2011-2016 он



ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого: Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2016 оны 11 дугаар сарын байдлаар 58977.8 сая төгрөг, нийт зарлага цэвэр зээлийн дүн 58519.0 сая төгрөг болж, орон нутгийн төсвийн нийт тэнцэл 458.8 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан байна.

Орон нутгийн нийт төсвийн төлөвлөгөөний биелэлтийг нэр тус бүрээр нь доорх хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 4. Төсвийн урсгал орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт орлогын дүн	52770377.5	58977835.1	6207457.6	11.8
Урсгал орлого	22704048.6	29493765.5	6789716.9	29.9
1. Татварын орлого	22217426.0	28605136.2	6387710.2	28.7
Орлогын албан татвар	11247825.5	11298212.7	50387.2	0.4
Өмчийн татвар	59200.0	26848.0	-32352.0	54.6
Бусад татвар	10910400.5	17280075.5	6369675.0	58.4
2.Татварын бус орлого	486622.6	888629.3	402006.7	82.6
Тусламжийн орлого	30066328.9	29484069.6	-582259.3	1.9

Төсвийн төлөвлөгөөний биелэлт өмчийн татвар, тусламжийн орлогоос бусад нэр төрөл дээр төлөвлөснөөс давж бүрдсэн байна.

Төсвийн зарлага: Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 2016 оны 11 дугаар сарын байдлаар 58519.0 сая төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс 1558.9 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар төсвийн зардлыг хэмнэсэн байна.

Зураг 7. Төсвийн зардал



Төсвийн нийт зарлагын 30.2 хувийг цалин хөлс, 3.4 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 41.2 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 9,6 хувийг татаас, 4.9 хувийг урсгал шилжүүлэг, 10.7 хувийг хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 5. Төсвийн зарлага


Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	60077977.7	58519016.1	-1558961.6	2.6
А. Урсгал зардлын дүн	52763471.2	52264767.8	-498703.4	0.9
1.Бараа үйлчилгээний зардал	38486045.5	43715310.6	5229265.1	13.6
1.1 Цалин хөлс	18048916.9	17660778.8	-388138.1	2.1
1.2 НДШ хураамж	2037023.7	1967493.4	-69530.3	3.4
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	18400104.9	24087038.4	5686933.5	30.9
2.Зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	-
3.Татаас ба урсгал шилжүүлэг	14277425.7	8549457.2	-5727968.5	40.1
3.1 Татаас	5662855.0	5662855.0	0.0	-
3.2 Урсгал шилжүүлэг	8614570.7	2886602.2	-5727968.5	66.5
Б. Хөрөнгийн зардал	7314506.5	6254248.3	-1060258.2	14.5
1. Хөрөнгө оруулалт	7314506.5	6254248.3	-1060258.2	14.5



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн хэлтсийн 2016 оны 11-р сарын мэдээгээр ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй 1946 иргэн бүртгүүлсэн байна. Нийт ажил хайж байгаа эмэгтэйчүүд 948 буюу 48.7 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 13 буюу 0.7 хувь байна. Насны бүлгээр авч үзвэл нийт ажил хайж байгаа иргэдийн 209 буюу 10.7 хувь нь 15-24 насны, 798 буюу 41.1 хувь нь 25-34 насны, 518 буюу 26.6 хувь нь 35-44 насны, 328 буюу 16.8 хувь нь 45-54 насны, 93 буюу 4.8 хувь нь 55 дээш насны хүмүүс байна.

Зураг 8. Ажил идэвхитэй хайж байгаа иргэдийн тоо боловсролын түвшингээр



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр 2016 оны 11 дүгээр сарын байдлаар дүүргийн хэмжээнд 3854 эх амаржиж, 3888 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс амаржсан эхийн тоо 360 буюу 8.6 хувь, амьд төрсөн хүүхэд 365 буюу 8.6 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 6. Эмнэлгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт		2015.11	2016.11	Зөрүү	Хувь
Нийт үзлэг		696269	722303	26034	3.7
Үүнээс:	Урьдчилан сэргийлэх	273635	280188	6553	2.4
	Амбулаторид	198438	212298	13860	7.0
	Диспансерийн хяналт	86557	88334	1777	2.0
	Гэрийн үзлэг	133461	137450	3989	3.0
	Гэрийн дуудлагын үзлэг	4178	4033	-145	3.5
Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг		224356	249021	24665	11.0
Өрхийн эмчийн үзлэг		471913	473282	1369	0.3
Бүртгэгдсэн өвчлөл		32276	43123	10847	33.6
Үүнээс:	Шинэ	20804	28067	7263	34.9
	Хуучин	11472	15056	3584	31.2
Бүртгэгдсэн хорт хавдар		41	72	31	75.6
Осол гэмтэл		288	384	96	33.3
Хэвтсэн өвчтөн		8824	9433	609	6.9
Эмнэлгийн нас баралт		32	42	10	31.2
Хоног болоогүй нас баралт		14	9	-5	35.7
Эмчлэгдсэн өвчтөн		8794	9360	566	6.4
Түргэн тусламжийн дуудлага		3316	3400	84	2.5

2016 он гарсаар 640 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 117 хүнээр буюу 15.4 хувиар буурсан байна. Нийт нас баралтын дотор нялхсын эндэгдэл 45 буюу 7.0 хувь, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 1.4 хувийг тус тус эзэлж байна. Нялхсын эндэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 2.3 хувиар өссөн байна. 2016 оны 11 сарын байдлаар 722.3 мян.хүн үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 26.0 мян.хүн буюу 3.7 хувиар эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний хүний тоо 9360 болж өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 9. Нийт үзлэг, төрлөөр



Хүснэгт 7. Халдварт өвчин

Үзүүлэлт	2015.11	2016.11	Зөрүү	Хувь	
Халдварт өвчин	4148	4027	-121	2.9	
Үүнээс:	Гепатит	56	25	-31	55.3
	Цусан суулга	249	283	34	13.6
	Сальмоннез	13	16	3	23.1
	Хоолны хордлого	58	93	35	60.3
	Менингит	1	0	-1	100.0
	Салхин цэцэг	246	263	17	6.9
	Гахайн хавдар	6	19	13	2.1 дахин
	Улаан эсэргэнэ	51	117	66	1.3 дахин
	Ёлом	8	11	3	37.5
	Улаан бурхан	2110	1758	-352	16.7
	Улаанууд	5	0	-5	100.0
	Бруцеллөз	2	1	-1	50.0
	Гар, хөл, ам	116	391	275	2.3 дахин
	Тэмбүү	525	429	-96	18.3
	Заг хүйтэн	176	139	-37	21.0
	Трихомониаз	102	110	8	7.8
	Мөөгөнцөр	96	31	-65	67.7
	Сүрьеэ	312	308	-4	1.3
	Бусад	16	21	5	31.2

Дүүргийн хэмжээнд 2016 оны 11 сарын байдлаар бүртгэгдсэн халдварт бус өвчлөл 43.1 мянгаболж өнгөрсөн оны мөн үеэс 33.6 хувиар өссөн байна. Халдварт өвчин 4027 бүртгэгдсэн нь өмнөх оноос 2.9 хувиар буурсан нь улаан бурхан өвчний бууралттай холбоотой байна. Бэлгийн замын халдварт өвчин нийт халдварт өвчний 17.6 хувийг эзэлж байна. БЗХӨ өнгөрсөн оны мөн үеэс 21.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



НИЙГМИЙН ДААТГАЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны 11-р сард төсвийн 216 байгууллагын 23213 албан хаагчид, хувийн хэвшлийн 3782 аж ахуйн нэгжийн 65782 албан хаагчид, сайн дурын 12243 иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. Эрүүл мэндийн даатгалд 41914 иргэн хамрагдсан. Үүнээс төр эрүүл мэндийн

даатгалыг хариуцсан даатгуулагч 25390 байна.

Хүснэгт 8. Тэтгэвэр олголт

	Хүний тоо	Олгосон тэтгэмж	
		Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Өндөр настан	15506	57658.3	57316.5
Тахир дутуу	3167	8378.3	7989.7
Тэжээгчээ алдсан	1015	2366.2	2716.9
Дүн	19688	68402.8	68023.1



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны 11-р сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 14.0 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд, 2.8 хувийг хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлогод тус тус хуваарилсан байна.

Хүснэгт 9. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, сая.төг

Үзүүлэлт	Үнийн дүн
Нийгмийн халамжийн сангийн орлого	12596.8
1. Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн төсвийн санхүүжилт	3595.8
a) Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	1768.8
b) Алдарт эхийн одонгийн тусламж	1100.0
c) Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	355.0
d) ОНОТХҮ үйлчилгээний санхүүжилтын орлого	22.5
e) Хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлого	349.5
2. Нийгмийн халамжийн сан	8982.5
a) Төсвийн санхүүжилтын орлого	8982.2
b) Бусад орлого	0.3
3. Хүүгийн орлого	18.5

Зарлагын нийт дүн	11526.4
1. Нийгмийн халамжийн сан	8590.5
2. Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	1806.2
3. Алдарт эхийн одонгийн тусламж	1107.2
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	-
5. Хүнс тэжээлийн хөтөлбөр	-
6. ОНОТХ. үйлчилгээ	22.5

Нийгмийн халамжийн сан нь 2692 хүнд халамжийн тэтгэвэр, 5898 хүнд асаргааны мөнгөн тэтгэмж, 12364 хүнд ахмад настаны хөнгөлөлт тусламж, 7653 хүнд жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн мөнгөн тэтгэмжийг зарцуулсан байна.



УЛААН ЗАГАЛМАЙН ЧИГЛЭЛЭЭР

Дүүргийн “Улаан загалмайн хороо” 2016 оны 11-р сард нийт 45 хүнд 459.7 мян.төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 631 хүн, 2,259.1 мян.төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан хүн зардалаар

Үзүүлэлт	2015 он 11-р сар			2016 он 11-р сар		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/
Халамж үйлчилгээ	17	676	2718800	5	43	398700
Анхны тусламжийн сургалт	10	131	-	6	153	
Гамшгийн тусламж			-	1	2	61000
Донорын өдөрлөг	2	70	-	3	121	
Дүн	29	877	2718800	15	319	459700

Мөн анхны тусламжийн 6 удаагийн сургалт зохион байгуулж, сургалтанд нийт 153 иргэн, донорын өдөрлөг арга хэмжээг 3 удаа зохион байгуулж 121 иргэнийг хамруулсан байна.



АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО

2016 оны 11 дугаар сард татварын хэлтсийн мэдээлэл боловсруулалтын санд бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо 15568 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.4 хувиар буюу 659 аж ахуй нэгж байгууллагаар нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагын 77.2 хувь

буюу 12020 байгууллага нь ХХК байна. Оны эхнээс нийт 883 байгууллага шинээр бүртгэгдэж, 604 байгууллага хасагдсан байна.

Хүснэгт 11. Аж ахуй нэгж байгууллагын тоо

ААНБ-ын төрөл	ААНБ-ын хариуцлагын хэлбэр	2015.09	2016.09
ААН	ХК	9	13
	ХХК	11625	12020
	ББН	120	127
	ЗБН	88	95
	ХХН	34	45
	Хоршоо	53	48
	Хадгаламж зээлийн хоршоо	67	59
	Төрийн өмчит үйлдвэрийн газар	27	33
	ОНӨҮГ	7	12
	Салбар	740	728
	Төлөөлөгчийн газар	8	22
	Төлөөний газар	1	3
	Боловсролын сургалтын байгууллага	1	1
	Нийт	12780	13206
	Төсөв болон ТББ	Төсөвт байгууллага	262
Төрийн бус байгууллага		1533	1716
Шашны байгууллага		40	42
Сан		95	108
Олон нийтийн байгууллага		199	206
Нийт		2129	2362
Бүгд	14909	15568	



АЖ ҮЙЛДВЭР


Аж үйдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2016 оны 11 сард 1692.9 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 42.5 хувь буюу 718.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь хувцас үйлдвэрлэл 43.3 хувь, хүнс үйлдвэрлэл 9,6 хувь өсөж, хэвлэлийн үйлдвэрлэл 30,5 хувь өсөж, бусад үйлдвэрлэл 84,1 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 12. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /сая.төг/

Салбар		2015.11	2016.11	Өсөлт, бууралт/%/	Зөрүү
Бүгд		974.3	1692.9	42.5	718.6
Үүнээс:	Хувцас үйлдвэрлэл	334.8	590.7	43.3	255.9
	Хүнс үйлдвэрлэл	420.3	464.9	9.6	44.6
	Хэвлэлийн үйлдвэрлэл	152.9	220.0	30.5	67.1
	Бусад үйлдвэрлэл	66.3	417.3	84.1	351

2016 оны 11 дугаар сарын байдлаар нийт үйлдвэрлэлийн 34.9 хувийг хувцас үйлдвэрлэл, 27.5 хувийг хүнс үйлдвэрлэл, 13.0 хувийг хэвлэлийн үйлдвэрлэл, 24.6 хувийг боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Зураг 10. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн



ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэний бүртгэлийн үйлчилгээ:

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2016 оны 11-р сарын байдлаар иргэний бүртгэлийн 8 төрлийн үйлчилгээг 34059 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар, өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 13. Иргэний бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт		2015.11	2016.11
Нийт		33565	34059
Шинэ төрсөн		3924	3786
Гэрлэлт		857	872
Гэр бүл цуцлалт		278	291
Хүүхэд үрчлэлт		65	54
Эцэг тогтоосон		1910	1849
Овог, нэр өөрчлөх		210	229
Иргэний үнэмлэх олголт	16 нас хүрч шинээр авсан	1842	1944
	дахин олголт	4697	5580
Шилжилт хөдөлгөөн	шилжин ирсэн	7711	9315
	шилжин явсан	12071	10939

Эд хөрөнгийн бүртгэл үйлчилгээ:

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2016 оны 11-р сарын байдлаар 1622 иргэн, аж ахуй нэгж байгууллагад эд хөрөнгийн бүртгэлийн 5 төрлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Хүснэгт 14. Эд хөрөнгийн бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт	Үйлчлүүлсэн тоо			Үйлчилгээний хөлс /мян.төг/		
	Нийт	Газар	Газраас бусад	Нийт	Газар	Газраас бусад
Нийт	1622	662	960	16242.6	4479.5	11763.1
Анхны бүртгэл	92	29	63	44.2	20.0	24.2
Өмчлөх эрх шилжих гэрээ	202	67	135	4948.0	1580.0	3368.0
Барьцааны гэрээ	1109	498	611	9120.4	2240.5	6879.9
Бусад гэрээ	5	-	5	50.0	-	50.0
Лавлагаа, хуулбар	173	56	117	1508.0	495.0	1013.0
Бүртгэлд өөрчлөлт оруулах	41	12	29	572.0	144.0	428.0

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2016 оны 11 сарын байдлаар Дүүргийн Засаг даргын 19 удаагийн захирамжаар 441 иргэний газрын эрхийг баталгаажуулж, газар эзэмших эрхийн нэр шилжүүлэх, талбайг өөрчлөх, хугацаа сунгах зэрэг газрын асуудлыг шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд зуслангийн газар өмчлүүлж эхэлсэнтэй холбогдуулан иргэдээс /www.land.ulaanbaatar.mn/ цахим сайтад бүртгүүлсэн 1545 иргэний бүртгэлийг шүүж тухай бүрт хариу өгч ажиллаж байна.

Хүснэгт 15. Үзүүлсэн үйлчилгээ

№	Нэр	Тоо
1	Мэдээллийн санд нэр сольсон	291
2	Нэр сольсон	21
3	Хаяг сольсон	0
4	Хаяг оруулсан	45
5	Байшин оруулсан	129
6	Талбай хассан	27
7	Талбай нэмсэн	16
8	Өмчилсөн газар хуваасан	26
9	Зураг нийлүүлсэн	2
10	Томоор орсон зураг хуваасан	17
11	Зураг өөрчилсөн	42
12	Шинээр оруулсан	239
13	Эзэмшлийн хэлбэр өөрчилсөн	3
14	Захирамж тэмдэглэсэн	16
15	Бүртгэл оруулсан	2
16	Барьцаа бүртгэсэн	54
17	Барьцаа чөлөөлсөн	22

18	Регистр зассан	5
19	Өмчлөлийг тэмдэглэсэн	65
20	Байршил өөрчилсөн	10
21	Бусад	9
21	Архивын хавтас үүсгэсэн	20
	НИЙТ	1061

2016 он гарсаар газрын төлбөрийн 172.0 сая төгрөг, газрын гэрчилгээний төлбөр 8.6 сая төгрөг, бусад бүртгэлээс 1.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны 11 дугаар сарын байдлаар 7393.4 мян.м² зам талбай цэвэрлэж, 100.2 мян.м³ хог тээвэрлэсэн байна. Өнгөрсөн оноос цэвэрлэсэн талбай 1267.4 мян/м² буюу 17.1 хувиар буурч, тээвэрлэсэн хог 5.3 мян/м³ буюу 5.6 хувиар өссөн байна. Ажил үйлчилгээний орлого 5836.8 сая төгрөг болж өнгөрсөн оноос 1274.6 сая төгрөг буюу 27.9 хувиар өссөн байна. Орлогын эх үүсвэрийг ангилвал 18.3 хувийг зам талбай, 36.8 хувийг гэр хорооллоос, 20.4 хувийг орон сууцнаас, 24.5 хувийг албан газраас тус тус олсон орлого эзэлж байна.

Хүснэгт 16. Тохижилтын ажил

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2015.11	2016.11	Зөрүү	%
Цэвэрлэсэн талбай		мян.м ²	8660.8	7393.4	-1267.4	14.6
Тээвэрлэсэн хог		мян.м ³	94.9	100.2	5.3	5.6
Үүнээс:	Орон сууц	мян.м ³	23.7	25.1	1.4	5.9
	Гэр хороолол	мян.м ³	42.7	45.1	2.4	5.6
	Албан газар	мян.м ³	14.2	15.0	0.8	5.6
	Зам талбай	мян.м ³	14.2	15.0	0.8	5.6
Ажил үйлчилгээний орлого		сая.төг	4562.2	5836.8	1274.6	27.9
Үүнээс:	Зам талбай	сая.төг	812.0	1067.0	255.0	31.4
	Гэр хороолол	сая.төг	1710.1	2146.4	436.3	25.5
	Орон сууц	сая.төг	1008.3	1192.4	184.1	18.2
	Албан газар	сая.төг	1031.7	1430.9	399.2	38.7

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2016 оны 11 сарын байдлаар дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 72 өргөдөл, гомдол ирснээс 70-г хуулинд заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй, шийдвэрлэх шатандаа явж байгаа 2 өргөдөл, гомдол хянагдаж байна.

Хүснэгт 17. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Ангилал	НИЙТ	Шийдвэрлэх шатандаа байгаа			Шийдвэрлэж хариу өгсөн		
		Хугацаан-даа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд	Хугацаан-даа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд
1800-1200 тусгай дугаарын утас	6	3	0	0	6	0	6
www.ub1200.mn цахим хуудас	2	0	0	0	2	0	2
Засгийн газрын 11-11 төв	6	0	0	0	6	0	6
Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв	25	1	0	1	24	0	24
Нутгийн захиргааны байгууллагууд	33	1	0	1	32	0	32
Smart UB аппликейшн, Clean UB аппликейшн	0	0	0	0	0	0	0
Мессеж	0	0	0	0	0	0	0
Шуурхай удирдлага, зохицуулалтын төв	0		0			0	
НИЙТ	101	2	0	2	70	0	70



ОСОЛ, ГЭМТ ХЭРЭГ

2016 оны 11 сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 2200 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар буюу 116 тохиолдлоор өссөн.

Хүснэгт 18. Гэмт хэрэг

Төрөл	Цагдаагийн I хэлтэст бүртгэгдсэн				Цагдаагийн II хэлтэст бүртгэгдсэн				
	2015.11	2016.11	Илрүүлэлтийн хувь	Хувь%/	2015.11	2016.11	Илрүүлэлтийн хувь	Хувь%/	
Хэргийн ангилал	Хөнгөн	585	686	62.5%	17.2%	362	341	87.5%	-5.8%
	Хүндэвтэр	580	492	52.3%	-15.2%	381	538	46.2%	41.2%
	Хүнд	85	61	73.5%	-28.2%	48	39	80%	-5.2%
	Онц хүнд	30	23	57.1%	-23.3%	13	20	77.8%	53.8%
Гэмт хэргийн төрөл	Хүн амь	1	2	100%	100%	10	11	100%	10%
	Учрал	4	5		25.0%	5	9		80%
	Залилан	220	247	64.5%	25.0%	42	29	92.9%	-30.9%
	Хүчин	2	4	75%	100%	9	12	50%	33.3%
	Танхай	90	59	69.4%	-34.4%	50	42	76.9%	-16%
	Булаалт	9	14	41.7%	55.5%	5	8	57.1%	60%

Хулгай	358	426	45.5%	19%	286	433	44%	51.4%
ББМГУ	211	247	89.0%	17.1	254	252	94.6%	-0.8%
Дээрэм	21	25	63.6%	19.0	20	22	82.4%	10%
ТХХАББАЖЗ	73	64	95.8%	-12.3%	60	41	100%	-31.7%
Бусад	291	169	63.8%	-41.9%	63	79		25.4%
Бүгд	1280	1262	59%	-1.4%	804	938	58%	16.7%

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ

Тус тасгийн алба хаагчдын гудамж замд хийсэн хяналт шалгалтаар 2016 оны 11 сард нийт 6638 зөрчил илрүүлсэнээс Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 27.1 дэх хэсгийн заалт зөрчин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 229, мөн хуулийн 31.2.3, 32.2, 43.2, 52.1 дэх хэсгүүдэд заасан зөрчилтэй 25 тээврийн хэрэгслийг түр саатуулан журамлан Жолоочийн даатгалын тухай хуулийн 28.1.1 дэх хэсэгт заасан зөрчилтэй 0, улсын дугаарын хязгаарлалт 662, бүрэн бус 623, хамгаалах бүс хэрэглээгүй 1050, нийт 6334 жолоочийг 125,995,000 төгрөгөөр торгож ажиллав. Замын Цагдаагийн газар болон бусад албадаас зарлагдсан 8 дугаарыг илрүүлэн ерөнхий жижүүрт хүлээлгэн өгсөн. Цагдаагийн шалгах төхөөрөмж ашиглан 2013 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлж ASAP санд бүртгэлтэй сэжигтэн яллагдагч тээврийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнд оролцож байсан 2, Цагдаагийн нийтлэг үүргээр 4 зөрчил тус тус илрүүлсэн. Зам тээврийн ослын нийт 1101 дуудлага мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн байна. Нийт бүртгэгдсэн гомдол мэдээллээс 30 буюу 2.7 хувь нь эд материалын хохиролтой зам тээврийн осол байна. Зам тээврийн ослын улмаас 27,342,000 төгрөгийн материаллаг хохирол учирсаны 27,342,000 төгрөгийн хохирлыг хэрэг бүртгэлтийн шатанд нөхөн төлүүлсэн нь нөхөн төлүүлэлт 100 хувьтай байна.



СОЁЛ УРЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2016 оны эхний 11 сарын байдлаар Чингэлтэй дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс:

- Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулж, 2684 хүүхэд багачууд, иргэд хамрагдсан байна.

Дүүргийн Засаг даргын 1 удаагийн захирамжаар 1 ахмад настаныг асрамжийн газар явуулсан.

ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ

Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв нь 2016 оны 11-р сард нийт 962 хүнд хүрч ажилласан байна.

Хүснэгт 19. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалалын чиглэлээр хийсэн ажил

№	Үйл ажиллагааны чиглэл	Зохион байгуулагдсан ажил	Хамрагдсан хүний тоо
1	Хүүхдийн тусламжийн 108 утас	Ирсэн дуудлагын тоо-4	4
2	Ажилласан кейс	Асран хамгаалагч тогтоолгох - 0 Бэлгийн хүчирхийлэл -0 Бие махбодийн хүчирхийлэл - 0 Зам тээврийн осол - 0 Хүүхдийг үл хайхрах хүчирхийлэлд өртүүлсэн - 3 Хаагдсан кейсийн тоо - 0 Хараа хяналтгүй, гуйлга гуйдаг тэнэмэл хүүхдийн асуудал - 0 Шинжээчийн дүгнэлт - 0 Хүүхдийн амь нас үрэгдсэн - 0 Хүүхдийн эрхийн зөрчлийн - 1 кейс дээр ажилласан.	4
3	Хүүхэд хамгааллын чиглэлээр	Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 16 хорооны 2 хүүхэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн. Гэрээсээ дайжсан хүүхдийг эргэн гэрт нь нэгтгэсэн. ажилласан. ЗҮл хайхрах хүчирхийлэлд өртсөн 1 хүүхдийн хаягийг тогтоон Сүхбаатар дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвд шилжүүлсэн.	3
4	Хүүхэд хөгжлийн чиглэлээр	Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар Оны Шилдэг хүүхэд шалгаруулах үйл ажиллагааны талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлгээр Нийслэлийн болон 9 дүүргийн шилдэг хүүхэд шалгаруулах үйл ажиллагааны дэлгэрэнгүй зааварчилгаа болон Хүүхдийн эрхийн конвенц батлагдсаны 27 жилийн ойн хүрээний ажлуудын төлөвлөгөө гаргасан. 2016 оны 10 сарын 27-ны өдөр, 11 сарын 14-15ны өдрүүдэд 2 удаагийн Хүүхэд харах үйлчилгээний байруудад шалгалт хийсэн. 2016 оны 11 сарын 17-ны өдөр Хүүхдийн эрхийн конвенц батлагдсаны 27 жилийн ойн хүрээнд “Хүүхдийн эрх, үүрэг, оролцоо” чадвахижуулах сургалтыг Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас зохион байгуулсан. 2016 оны 11 сарын 01-ээс 11 сарын 17-ны өдрүүдэд Оны шилдэг хүүхэд шалгаруулах үйл ажиллагааны хүрээнд Дүүргийн шилдэг сурагчдыг шалгаруулах ажлын бэлтгэл ажлыг хангаж ерөнхий боловсролын сургуулиудын 40 сурагчдын материалыг хүлээн аваад байна.	40

5	Гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр	“Хүүхдэд ээлтэй Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн 377 жилийн ойг угтан “Хүн бүрийн хүсэн мөрөөддөг аз жаргалтай гэр бүл” сэдэвт зургийн уралдааныг Чингэлтэй дүүргийн ЕБС-ийн сурагчид болоод цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд 2016 оны 10 дугаар сарын 10-26-ны өдрийн хооронд зарлан, амжилттай зохион байгуулж, нийт 31 бүтээл хүлээн авч, шилдэг бүтээлүүдийн эздэд шагналыг 2016 оны 10 дугаар сарын 28-ны гардуулсан.	31
6	Гэр бүлийн хамгааллын чиглэлээр	Иргэдэд “Монгол улсын Соёлын тухай хууль”-аар хүлээлгэсэн удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх журамт үүргийг биелүүлэх, дүүргийн хэмжээнд угийн бичиг хөтөлдөг айл өрхийн тоог нэмэгдүүлэх зорилготойгоор 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр “Угийн бичиг хөтлөх нь” сургалтыг дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв, Соёлын төв, хамтран 15 дугаар хорооны Иргэний танхимд амжилттай зохион байгуулсан. Иргэдэд “Монгол улсын Соёлын тухай хууль”-аар хүлээлгэсэн удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх журамт үүргийг биелүүлэх, дүүргийн хэмжээнд угийн бичиг хөтөлдөг айл өрхийн тоог нэмэгдүүлэх зорилготойгоор 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр “Угийн бичиг хөтлөх нь” сургалтыг дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв, Залуучуудын хөгжлийн төв, Соёлын төв хамтран “Соёлын төв”-ийн зааланд амжилттай зохион байгуулсан.	

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ

Тус хэлтэс нь 2016 оны 11 сарын байдлаар нийт 2571 нэгжид шалгалт, 878 нэгжид хяналт хийж гүйцэтгэсний 75.2 хувь нь ААНБ-г, 24.8 хувь нь иргэнийг хамарсан байна.


Хүснэгт 20. Хяналт, шалгалт, зөрчил, торгууль шийтгэвэрийн мэдээ, тасгаар

Үзүүлэлт		Нийт дүн	ХХААҮҮБОХ-ын тасаг	ЭМБХ-ын тасаг	ХНХХ-ын тасаг
Хяналт	ААНБ	531	126	386	19
	Иргэн	347	203	144	0
	Дүн	878	329	530	19
Шалгалт	ААНБ	2063	970	981	112
	Иргэн	508	440	64	4
	Дүн	2571	1410	1045	116
Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил	Нийт илэрсэн	1573	672	885	16
	Арилгасан	963	420	532	11
Торгууль, шийтгэвэр	Тоо	203	113	89	4


	Үнийн дүн мян.төг	36488	16890	18912	686
Зөвлөн туслах сургалт, сурталчилгаа	ААНБ	387	234	117	11
	Иргэн	445	95	350	0
	Дүн	862	329	467	11

Энэ хугацаанд нийт 1573 зөрчил илэрсний 963 буюу 61.2 хувийн зөрчлийг арилгасан ба нийт 203 торгууль, шийтгэвэрт нийт 36.4 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Зураг 11. Хийсэн хяналт тоо, тасгаар



Зураг 12. Хийсэн шалгалтын тоо, тасгаар



АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, ГАМШИГ

Хэлтсийн Аврах, гал унтраах 10 дугаар анги нь 2016 оны 11 дугаар сарын байдлаар 3011 удаагийн 7534 цагийн харуул ээлжийн үүрэг гүйцэтгэх явцад гамшиг ослын дуудлагаар 727 удаа гарснаас удаагийн гамшгийн голомтод 462 удаа ажиллаж гал түймэр дээр нийт 205.0 цаг ажиллаж 530.7 тонн ус, 915 л хөөс шатах тослох материал дизель түлш 23.0 мянган литр буюу 35.0 сая төгрөгийг зарцуулан аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 5.1 тэрбум төгрөгний өмч хөрөнгийг авран хамгаалж, 208 гал түймрийг иргэд унтрааж, 10 гал түймэр өөрөө унтарч, худал дуудлагаар 17 удаа тус тус гарч ажиллан 259 байшин, барилга, 397 хүний амь насыг авран хамгаалсан байна.

ЦЭРГИЙН ШТАБ

Зэвсэгт хүчний анги байгууллагуудтай дайчилгааны бэлэн байдлын нөхөн хангалтын тодотголыг зохион байгуулж явуулав. Дайчилгааны даалгаврын дагуу бэлтгэл офицер, түрүүч байлдагчдыг оногдуулан данслах, орон нутгийн цэргийн удирдлагыг хороодоор дамжуулан тодотгосон. 2016 оны хоёрдугаар ээлжээр халагдсан дайчдыг дайчилгааны бэлтгэл нөөцөөр оногдуулан дансалсан.

2016 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар ирээгүй иргэдийн нэрсийг гаргаж хуваарь гарган батлуулан, мэдэгдэх хуудсаар дуудан шалтгаан нөхцлийг тодруулан ажиллаж байна. Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын шилжилт,хөдөлгөөнийг Нийслэлийн Засаг Даргын 2009 оны 101 тушаалаар батлагдсан журмын дагуу мэдээллийн санд оруулж баяжилт хийн ажиллаж байна.

Дүүргийн Засаг Даргын баталсан удирдамжийн дагуу байгууллага аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас “Сүлжээний аюулгүй байдал” сэдвээр нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын МАБ-ын офицеруудын сургалтыг 2016 оны 11-р сарын 10-ны өдөр зохион байгуулж явуулан мэдээг Нийслэлийн цэргийн штабт цаг хугацаанд нь дамжуулж байв.

АХМАДЫН ХОРОО

Монголын ахмадын холбооноос зохион байгуулсан ахмад настны тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг, Нийслэлийн ахмадын байгууллагуудын зөвлөлдөх уулзалтанд ахмадын зөвлөлийн дарга нарыг оролцуулж,харидцан санал солилцсон уулзалт боллоо.

Ахмадын хорооны дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан болон төлөвлөгөөт ажлуудаас дараахь уралдаан тэмцээнүүдийг зохион багуулж явууллаа.Үүнд:

Дүүргийн 19 хороодын Ахмадуудын дунд 4.5.13.15-р дүгээр хорооны нэрэмжит гранд гольф,шатар, дардас,гар бөмбөгийн тэмцээнүүдэд 19 хорооноос 256 тамирчин хурд, хүч авхаалж самбаагаа сорин амжилттай оролцлоо.



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ:

WWW.1212.MN

WWW.UBSTAT.MN

WWW.CHINGELTEI.GOV.MN



Хянасан: Хэлтсийн дарга Д.МӨНХЗУЛ

*Танилцуулга нэгтгэсэн:
мэргэжилтэн Х. Энхбулаг*

И-мэйл хаяг: chingeltei@nso.mn
Хаяг: Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг,
Нийслэлийн төр захиргааны
III байр 401 тоот
Утас: 70113013
70130767
11-310767